



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/25

Дархан

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.10 дэх хэсгүүд, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйл, 13.15, 13.19 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн яам Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн Чиглэл, Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх комиссын 2024 оны №09 дүгээр хурлаар хойшлуулсан “Ариун дарь” ХХК-ийн Дархан ариутгал, халдваргүйтгэл, 2025 оны №01 дүгээр хурлаар хойшлуулсан “Энхийн тун” ХХК-ийн Эмийн сан зэрэг байгууллагуудын тусгай зөвшөөрлийн төслийн шаардлага хангагдсан тул тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга (М.Мөнхбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Б.Золбаясах) нарт тус тус үүрэг болгосугай.



Б.ЭРДЭНЭТУЛГА

4525010088

